

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/043/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 261628 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч Ниямазон аудит ХХК, захирал З.Цээнээ Утас: 99135906 Цахим хаяг: audit@nmz.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

Холбоо. 03.14 № 01/328
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ХОТЫН
ХӨГЖЛИЙН КОРПОРАЦИ ХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.САНДАГСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Улаанбаатар хотын хөгжлийн корпорац ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,028,543.2 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Тохиолдсон байх", "Оршин байх", "Толилуулга", "Нийцсэн бөгөөд зохистой байх" "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Компани тайлант онд 3,544,939.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 2,405,784.5 мянган төгрөгийг зарцуулж, 1,013,894.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Компани тайлант онд нийтийн тээврийн хэрэгслийг төлбөртэй ашиглуулах гэрээг 12 аж ахуйн нэгжтэй байгуулж 348 автобусыг хүлээлгэн өгсөн. Аж ахуйн нэгжүүд автобусны 95,956,260.0 мянган төгрөгийн өртгийг 7 жилийн хугацаанд эргэн төлөх ба компани гэрээний биелэлтийг хянах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах ажлыг амжилттай зохион байгуулан ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компани Эрдэнэс Баянбогд ХХК, Улаанбаатар энержи ХХК, Улаанбаатар такси каб ХХК гэсэн 3 охин компанитай үйл ажиллагаа явуулж байна. Компанийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 98.8 хувийн хэрэгжилттэйгээр гүйцэтгэн, тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	11,811,233,267.86	7,285,714,839.70
1.1.02	Дансны авлага	104,100,000.00	46,319,307.14
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	343,053,279.96	100,940,266.93
1.1.04	Бусад авлага	920,333,124.67	7,401,510,864.78
1.1.06	Бараа материал	2,050,382.12	7,823,922.85
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	7,709,486.35	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,188,479,540.96	14,842,309,201.40
1.2.01	Үндсэн хөрөнгө	25,967,892,939.35	25,234,976,543.72
1.2.02	Биет бус хөрөнгө	1,487,475,151.43	1,503,684,605.91
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	67,520,000.00	66,840,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	27,522,888,090.78	26,805,501,149.63
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	40,711,367,631.74	41,647,810,351.03
2.1.1.01	Дансны өглөг	-	1,731,624.14
2.1.1.02	Цалингийн өглөг	-	265,992.06
2.1.1.03	Татварын өр	88,332,010.52	28,349,491.97
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	131,610.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	-	2,184,400.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	53,976,937.50	127,194,337.50
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	142,308,948.02	159,857,455.67
2.2	Өр төлбөрийн нийт дүн	142,308,948.02	159,857,455.67
2.3.01	Өмч: - төрийн	11,670,000,000.00	11,670,000,000.00
2.3.03	- хувьцаат	11,670,000,000.00	11,670,000,000.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	4,890,302,866.77	4,890,302,866.77
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	23,637,185,617.28	23,637,185,617.28
2.3.09	Хуримтлагдсан ашиг	371,570,199.67	1,290,464,411.31
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	1,662,004,563.47	1,013,894,211.64
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(1,290,434,363.80)	276,570,199.67
2.3.11	Эздийн өмчийн дүн	40,569,058,683.72	41,487,952,895.36
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	40,711,367,631.74	41,647,810,351.03

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,310,232,794.31	2,081,321,125.29
2	Борлуулалтын өртөг	1,043,928,643.99	1,334,308,840.65
3	Нийт ашиг(алдагдал)	1,266,304,150.32	747,012,284.64
4	Түрээсийн орлого	386,397,123.90	494,410,490.72
5	Хүүний орлого	1,453,536,858.57	969,208,112.69
8	Бусад орлого	154,545,454.54	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	916,201,368.82	957,927,855.71
12	Бусад зардал	448,111,321.67	97,493,178.90
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(8,108.67)	9,293.85
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(16,054,632.40)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	1,896,462,788.17	1,139,164,514.89
19	Орлогын татварын зардал	234,458,224.70	125,270,303.25
20	Татварын дараах ашиг (алдагдал)	1,662,004,563.47	1,013,894,211.64
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,662,004,563.47	1,013,894,211.64
24	Орлогын нийт дүн	1,662,004,563.47	1,013,894,211.64
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31	1,000,000,000.00	4,890,302,866.77	32,597,829,856.28	(1,295,434,363.80)	37,192,698,359.25
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	5,000,000.00	5,000,000.00
03	Залруулсан үлдэгдэл	1,000,000,000.00	4,890,302,866.77	32,597,829,856.28	(1,290,434,363.80)	37,197,698,359.25
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,662,004,563.47	1,662,004,563.47
06	Өмчид гарсан өөрчлөлт	10,670,000,000.00	-	(8,960,644,239.00)	-	1,709,355,761.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
09	2023 оны 12 сарын 31	11,670,000,000.00	4,890,302,866.77	23,637,185,617.28	371,570,199.67	40,569,058,683.72
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(95,000,000.00)	(95,000,000.00)
11	Залруулсан үлдэгдэл	11,670,000,000.00	4,890,302,866.77	23,637,185,617.28	276,570,199.67	40,474,058,683.72
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,013,894,211.64	1,013,894,211.64
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
17	2024 оны 12 сарын 31	11,670,000,000.00	4,890,302,866.77	23,637,185,617.28	1,290,464,411.31	41,487,952,895.36

Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,991,372,909.95	3,050,193,751.75
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,155,372,909.95	2,625,745,995.72
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	180,479,541.80
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	1,800,000,000.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	36,000,000.00	243,968,214.23
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,432,410,538.40	8,478,628,545.54
1.2.1	Ажиллагчдад төлсөн	634,528,998.20	901,017,454.91
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	200,396,828.64	243,907,543.94
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,946,481.50	11,425,935.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	16,014,134.48	58,804,442.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	19,082,575.00	31,270,781.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	980,138,008.39	282,522,800.61
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,572,303,512.19	6,949,679,588.08
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(441,037,628.45)	(5,428,434,793.79)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,474,481,283.57	969,208,112.69
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	20,944,425.00	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	1,453,536,858.57	969,208,112.69
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,623,950.00	66,322,040.91
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38,323,000.00	4,110,800.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,300,950.00	12,860,850.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	49,350,390.91
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,429,857,333.57	902,886,071.78
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	171,759,863.82	34,249.62
3.1.3	Төрөл бүрийн хандив	170,000,000.00	-
3.1.4	Бусад	1,759,863.82	34,249.62
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,176,059.49	3,955.77
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,408,087.00	-
3.2.5	Бусад	1,767,972.49	3,955.77
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	167,583,804.33	30,293.85
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,156,403,509.45	(4,525,518,428.16)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,654,829,758.41	11,811,233,267.86
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,811,233,267.86	7,285,714,839.70

Улаанбаатар хотын хөгжлийн корпорацн ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн 2024 оны 1 сарын 1-ний үлдэгдэл		11,811,233,267.86		
2	I. ОРЛОГЫН ДҮН	3,703,754,500.00	3,883,345,450.21	(179,590,950.21)	104.8
3	Үйл ажиллагааны орлого НӨАТ-гүй	2,622,958,636.36	2,550,538,125.02	72,420,511.35	97.2
4	Банкны хүүний орлого, тендерийн хураамж	818,500,000.00	969,208,112.69	(150,708,112.69)	118.4
5	Түрээс барьцаа		107,865,400.00	(107,865,400.00)	
6	Хувьцааны төлбөр		680,000.00	(680,000.00)	
7	Үйл ажиллагааны орлогоос төлөх НӨАТ	262,295,863.64	255,053,812.50	7,242,051.13	97.2
8	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,742,044,000.00	1,808,003,704.68	1,934,040,295.32	48.3
9	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,933,481,000.00	1,167,779,187.22	765,701,812.78	60.4
10	Цалин хөлс	1,705,316,000.00	1,002,181,074.03	703,134,925.97	58.8
11	НДШ	213,165,000.00	122,560,146.41	90,604,853.59	57.5
12	Тэтгэвэр тэтгэмж, шагнал урамшуулал	15,000,000.00	43,037,966.78	(28,037,966.78)	286.9
13	Харилцаа холбооны зардал	5,400,000.00	3,185,574.27	2,214,425.73	59.0
14	Утас,Интернет	4,200,000.00	2,986,467.00	1,213,533.00	71.1
15	Шуудан холбоо	1,200,000.00	199,107.27	1,000,892.73	16.6
16	Үйл ажиллагааны зардал	628,402,000.00	389,196,566.88	239,205,433.12	61.9
17	Оффис байр	78,000,000.00	69,349,175.00	8,650,825.00	88.9
18	Оффис хангамж	32,795,000.00	20,018,471.37	12,776,528.63	61.0
19	Сургалт семинар	15,000,000.00	14,100,000.00	900,000.00	94.0
20	Мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээ	102,314,000.00	78,584,800.00	23,729,200.00	76.8
21	Томилолт	96,000,000.00	65,237,589.00	30,762,411.00	68.0
22	Тээврийн хэрэгслийн зардал	31,765,000.00	30,904,700.00	860,300.00	97.3
23	Бусад зардал	24,000,000.00	2,717,233.27	21,282,766.73	11.3
24	ХАБЭ бусад зардал	19,800,000.00	13,200,000.00	6,600,000.00	66.7
25	Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэлтийн зардал	226,298,000.00	92,532,208.24	133,765,791.76	40.9
26	Газрын төлбөр	2,430,000.00	2,552,390.00	(122,390.00)	105.0
27	Маркетинг олон нийтийн үйл ажиллагааны зардал	57,400,000.00	54,791,004.02	2,608,995.98	95.5
28	Маркетинг зар сурталчилгаа	37,600,000.00	35,884,504.02	1,715,495.98	95.4
29	Хэвлэлийн зардал	19,800,000.00	18,906,500.00	893,500.00	95.5
30	Үндсэн хөрөнгийн нийт зардал	762,396,000.00	-	762,396,000.00	-
31	Элэгдлийн зардал	762,396,000.00		762,396,000.00	-
32	Татварын зардал	81,850,000.00	96,920,811.27	(15,070,811.27)	118.4
33	Хүүгийн орлогын татвар	81,850,000.00	96,920,811.27	(15,070,811.27)	118.4
34	Хөрөнгө оруулалт	104,725,000.00	24,165,650.00	80,559,350.00	23.1
35	Компьютер, программ хангамж	46,725,000.00	19,889,850.00	26,835,150.00	42.6
36	Тавилга эд хогшил	58,000,000.00	4,275,800.00	53,724,200.00	7.4

**Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын хураангуй тайлан**

37	Төлөөлөн удирдах зөвлөл	168,390,000.00	71,964,911.02	96,425,088.98	42.7
38	Цалин	143,280,000.00	64,020,000.00	79,260,000.00	44.7
39	НДШ	17,910,000.00	6,685,800.00	11,224,200.00	37.3
40	Хурлын зардал	7,200,000.00	1,259,111.02	5,940,888.98	17.5
41	Хөрөнгө оруулалт	10,022,849,420.00	6,481,172,531.02	3,541,676,888.98	64.7
42	Эрдэнэс баянбогд ХХК	9,352,849,420.00	6,436,822,140.11	2,916,027,279.89	68.8
43	Улаанбаатар Такси Каб ХХК	670,000,000.00	-	670,000,000.00	0.0
44	Улаанбаатар Энержи ХХК	-	44,350,390.91	(44,350,390.91)	
45	Өр төлбөр		120,007,010.52	(120,007,010.52)	
46	Мөнгөн хөрөнгийн 2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	(38,289,500.00)	7,285,404,833.26	(7,323,694,333.26)	

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг төсөвт төвлөрүүлэх	1	1,080.0	1	1,080.0								
Туршилтын цахилгаан 10 автобусны хөрөнгийн бүртгэлийн асуудлыг шийдвэрлүүлэх.	1	1,004,028.6	-	-	1	1,004,028.6		-	-	-	-	-
Монголын хүүхдийн ордон, Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн газрыг балансаа балансад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Түрээсийн авлага барагдуулах журамгүй	1	9,784.6	-	-	-	-	1	9,784.6	-	-	-	-
Тээврийн цагдаагийн газрын түрээсийн авлагыг барагдуулаагүй	1	13,650.0					1	13,650.0				
Дүн	5	1,028,543.2	1	1,080.0	1	1,004,028.6	3	23,434.6	-	-	-	-